

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЖИЖИГ ДУНД
ҮЙЛДВЭРТ АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОХ ТУХАЙ 1998 ОНЫ 189 ДҮГЭЭР
ЗӨВЛӨМЖ

Нэг. Тодорхойлолт, зорилго, хамрах хүрээ

1. Гишүүн орнууд нь үндэсний нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан зохистой гэж үзэж болох шалгуур үзүүлэлтээр жижиг, дунд үйлдвэрийг ажил олгогчдын болон ажилчдын хамгийн өргөн төлөөлөл бүхий байгууллагуудтай зөвлөлдөн тодорхойлбол зохино. Энэхүү уян хатан байдал нь гишүүн орнуудыг тоо мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх зорилгоор нийтлэг тодорхойлолт тохиролцож гаргахад нь саад учруулахгүй байна.

2. Жижиг, дунд үйлдвэрүүд дараах хүрээнд үндсэн үүрэг гүйцэтгэж чадахыг хүлээн зөвшөөрч, дэмжихийн тулд гишүүн орнууд нь үндэсний нөхцөл байдалд тохирсон, практикт нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино.

а) бүрэн, бүтээлч, чөлөөтэй сонголт бүхий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих:

б) бүтээлч бөгөөд тогтвортой хөдөлмөр эрхлэлтэд хөтлөх орлого бий болгох боломж, баялаг бүтээлтийг өргөжүүлэх:

в) эдийн засгийн тогтвортой өсөлт ба өөрчлөлтөд уян хатан хандах чадвар:

г) нийгмийн эмзэг бүлгүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх:

д) дотоод хадгаламж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх:

е) мэргэжлийн сургалт, хүний нөөцийг хөгжүүлэх:

ё) бүсийн болон орон нутгийн түвшинд тэнцвэртэй хөгжлийг хангах:

ж) орон нутгийн чанартай зах зээлийн хэрэгцээнд илүүтэй нийцсэн бараа, үйлчилгээг нийлүүлэх:

з) амьдралын чанарыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулахуйц чанартай ажил, хөдөлмөрийн нөхцөлөөр хангагдах, түүнчлэн хүн амыг нийгмийн хамгаалалд өргөнөөр хамруулах боломжийг нээх:

й) инноваци, аж ахуй эрхлэлт, технологийн хөгжил болон судалгааг хөхиүлэн дэмжих:

к) дотоодын болон олон улсын зах зээлд гарах:

л) ажил олгогчид болон ажилчдын хоорондын сайн харилцааг бэхжүүлэх:

3. Энэхүү Зөвлөмжийн 2 дахь хэсэгт дурдсан жижиг, дунд үйлдвэрүүдийн үндсэн үүргийг бэхжүүлэхийн тулд гишүүн орнуудад нь ийм үйлдвэрүүдэд ажиллагч ажилчдад холбогдох бусад актуудаар олгогдсон үндсэн хамгаалалтыг эдлүүлэх замаар тэдний ашиг сонирхолыг хамгаалах зохих арга хэмжээг авч, тохирох механизмыг ашиглавал зохино.

4. Энэхүү Зөвлөмжийн заалтууд нь өмчийн хэлбэр нь (жишээ нь, хувийн болон төрийн компаниуд, хоршоод, нөхөрлөл, гэр бүлийн үйлдвэр, хувиараа эрхлэх аж ахуй). үл харгалзан эдийн засгийн үйл ажиллагааны бүх салбар, бүх төрлийн жижиг, дунд үйлдвэрүүдэд хамаарч үйлчилнэ.

Хоёр. Бодлогын болон хууль эрх зүйн хүрээ

5. Жижиг, дунд үйлдвэрийг өсгөж хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэхийн тулд гишүүн орнууд дараах арга хэмжээг авбал зохино:

а) эдийн засгийн хамгийн таатай орныг дэмжихэд чиглэсэн санхүү, мөнгөний болон хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх (ялангуяа инфляц, хүү болон валютын ханш, албан татвар, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн тогтвортой байдлын талаар):

б) өмчлөгчийн эрх, түүний дотор оюуны өмч, аж ахуйн байршил, гэрээг хэрэгжүүлэх, шударга өрсөлдөөний талаар хууль эрх зүйн зохих зохицуулалт, түүнчлэн хөдөлмөр, нийгмийн зохистой хууль тогтоомж бүрдүүлж хэрэгжүүлэх:

в) аж ахуй эрхлэх хүсэлтэй хүмүүст бэрхшээл учруулахуйц бодлогын болон хууль эрх зүйн арга хэмжээнээс зайлсхийх замаар аж ахуй эрхлэх сонирхолыг нэмэгдүүлэх:

6. Энэхүү Зөвлөмжийн 5 дахь хэсэгт заасан арга хэмжээнүүд дээр нэмэлт болгож нийгмийн зохих нөхцөлд бүтээмжтэй, тогтвортой ажлын байр бий болгох чадвар бүхий үр ашигтай, өрсөлдөх чадвартай жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих бодлогыг гаргавал зохино. Энэ зорилгоор гишүүн орнууд дараах бодлогыг авч үзвэл зохино:

1) Дараах нөхцөлүүдийг бүрдүүлэн:

а) хэмжээ буюу төрлөөс нь үл хамаарч бүх аж ахуйн нэгжид:

I) тэгш боломж олгох, ялангуяа зээлд хамрагдах, гадаад валют солих болон үйлдвэрийн зорилгоор импортын материал авах:

II) татварыг шударга ногдуулах:

б) жижиг, дунд үйлдвэрлэл дэх хөдөлмөр эрхлэлтийн чанарыг дээшлүүлэхийн тулд хөдөлмөрийн хууль тогтоомжийг ялгаварлалгүй хэрэгжүүлэх:

в) жижиг, дунд үйлдвэрүүд хүүхдийн хөдөлмөртэй холбоотой олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг мөрдөж хэрэгжүүлэхийг дэмжих:

2) Жижиг, дунд үйлдвэрүүдийг өсгөж, хөгжүүлэхэд учирч буй ялангуяа дараах шалтгаанаас үүдэлтэй хязгаарлалтуудыг арилгах:

- Зээл авах, хөрөнгийн зах зээлд хүрэхэд учрах хүндрэл
- Техник арга зүйн болон удирдлагын ур чадвар доогуур
- Мэдээлэл хангалтгүй
- Бүтээмж болон чанар доогуур
- Зах зээлийн хүрэлцээ муу
- Шинэ технологи эзэмшихэд хүндрэлтэй
- Тээвэр, холбооны дэд бүтэц муу
- Хөдөлмөр эрхлэлтийн нөхцлийн хүрсэн түвшин, хөдөлмөрийн хяналтын үр ашигтай ажиллагаа буюу хөдөлмөрийн нөхцөл болон холбогдох асуудлуудад хяналт тавих тогтолцоонд хохирол учруулахгүйгээр бүртгүүлэх, лиценз авах, тайлан мэдээ гаргах болон захиргааны шинжтэй бусад шаардлагууд, түүний дотор ажилтан авч ажиллуулахад саад учруулахуйц зохисгүй, учир дутагдалтай буюу хэт дарамттай шаардлагууд:

- Судалгаа ба хөгжилд үзүүлэх дэмжлэг хангалтгүй:

- Төрийн болон хувийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцоход хүндрэлтэй:

3) Албан бус хэвшлийг зохион байгуулалттай салбарын нэг хэсэг болгоход нь тусалж дэмжихэд чиглэсэн тодорхой арга хэмжээ, урамшуулалыг бий болгох

7. Ийм бодлогыг боловсруулах зорилгоор гишүүн орнууд нь шаардлагатай нөхцөлд дараах арга хэмжээг авбал зохино.

- Жижиг, дунд үйлдвэрүүдэд хэт дарамт ачаалал үүсгэхгүйгээр жижиг, дунд үйлдвэрийн салбар, түүний дотор түүн дэх хөдөлмөр эрхлэлтийн тоон болон чанарын үзүүлэлтүүдийн талаар үндэсний хэмжээнд тоо мэдээлэл цуглуулах:

- Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлого, зохицуулалтын жижиг, дунд үйлдвэрүүдэд, ялангуяа бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрүүдийн ажлын байр бий болгоход үзүүлж буй нөлөөллийг цогцоор нь судалж үзэх:

- Ажил олгогчдын болон ажилчдыг давуутай төлөөлөх байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр дараах зүйлүүдийг тодорхойлох зорилгоор хөдөлмөр, нийгмийн хууль тогтоомжийг хянан үзэх:

- Ийм хууль тогтоомж нь жижиг дунд, үйлдвэрүүдийн хэрэгцээ шаардлагыг хангах зэрэгцээ тэдгээрт ажиллагчдад зохистой хамгаалалтад хамруулж, хөдөлмөрийн нөхцөлийг хангаж буй эсэх:

- Сайн дураараа хамрагдах тогтолцоо, хоршоо байгуулах санаачлага болон бусад чиглэлээр нийгмийн хамгааллын нэмэлт арга хэмжээ авах шаардлага байгаа эсэх:

- Ийм нийгмийн хамгаалалд жижиг дунд үйлдвэрт ажиллагчдыг хамруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ, өвчилсний, ажилгүйдлийн, өндөр насны, үйлдвэрлэлийн ослын, гэр бүлийн, жирэмсний болон амаржсаны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, тэтгэмжийн холбоотой нийгмийн хамгааллын хууль эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулах зохистой нөхцөл бүрдсэн эсэх:

8. Засгийн газар нь эдийн засгийн хүндрэлийн үед жижиг, дунд үйлдвэрүүд болон тэдгээрт ажиллагчдад үр дүнтэй, далайцтай тусламж дэмжлэг үзүүлэхийг эрмэлзвэл зохино.

9. Эдгээр бодлогыг боловсруулахдаа гишүүн орнууд нь:

- Ажил олгогчдын болон ажиллагчдын хамгийн өргөн төлөөлөл бүхий байгууллагуудаас гадна шаардагатай гэж үзсэн бусад холбогдох эрх бүхий талуудтай зөвлөлдөж болно.

- Санхүү, мөнгөний асуудал, худалдаа аж үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, жендерийн тэгш эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон ерөнхий боловсрол, мэргэжлийн сургалтаар чадавх бэхжүүлэх хүрээний бусад бодлогуудыг харгалзан үзвэл зохино:

- Ажил олгогчдын болон ажиллагчдын хамгийн их төлөөлөл бүхий байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр эдгээр бодлогуудыг хянан үзэх механизмыг бий болгож, шинэчилж байвал зохино гэж зөвлөжээ.